

СОЛОНГОСЫН ҮНДЭСНИЙ МУЗЕЙ, ҮЗМЭРИЙН ТАНХИМ,
ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН БИЕ ДААСАН СУДАЛГААНЫ ХӨТӨЧ


Монгол хэл


30

ШИЛДЭГ БҮТЭЭЛ
СОЛОНГОСЫН ҮНДЭСНИЙ МУЗЕЙН




NATIONAL MUSEUM
OF KOREA






Уран баримал ба гар урлал Азийн урлаг 3F



Уран бичлэг ба уран зураг Хандивын зүйлс 2F



Дундад зуун ба орчин үеийн түүх Нэн эртний үе ба эртний түүх 1F

Нэн эртний үе ба эртний түүх

- 101 ПАЛИОЛИТЫН ТАНХИМ
- 102 ШИНЭ ЧУЛУУН ЗЭВСГИЙН ТАНХИМ
- 103 ХҮРЭЛ ЗЭВСГИЙН ТАНХИМ
- 104 БУЁО/САМАНЫ ТАНХИМ
- 105 ГУГУРЁ ТАНХИМ
- 106 БЭЮЖЭТАНХИМ
- 107 ГАЯА ТАНХИМ
- 108 ШИЛЛА ТАНХИМ
- 109 ШИЛЛА ТАНХИМ
- 110 ШИЛЛА ТАНХИМ
- 111 ШИЛЛАГИЙН НЭГДСЭН УЛСЫН ТАНХИМ
- 112 БАЛЕ ТАНХИМ

Дундад зуун ба орчин үеийн түүх

- 113 ГҮРЁ 1-р ТАНХИМ
- 114 ГҮРЁ 2-р ТАНХИМ
- 115 Сэдэвчилсэн үзэсгэлэн
- 116 ГҮРЁ 3-р ТАНХИМ
- 117 ЖУСОН 1, 2-р ТАНХИМ
- 118 ЖУСОН 3-р ТАНХИМ
- 119 ЖУСОН 4-р ТАНХИМ
- 120 ЖУСОН 5-р ТАНХИМ
- 121 Тусгай үзэсгэлэн

Уран бичлэг ба уран зураг

- 201 УРАН БИЧЛЭГИЙН ТАНХИМ
- 202 ЗУРГИЙН ТАНХИМ
- 203 Буддын уран зургууд
- 204 САРАНБАН

Хандивын зүйлс

- 205 Лее Хонкуны танхим
- 206 Хувь хүмүүсийн хандив
- 207 Ким Чонхакын танхим
- 208 Юу Канулын танхим
- 208 Парк Ёнсукийн танхим
- 209 Чой Юундугийн танхим
- 210 Канеко Казушигийн танхим
- 211 Канеко Казушигийн танхим
- 212 Канеко Казушигийн танхим
- 213 Хачиума Тадасугийн танхим
- 214 Иучи Исаогийн танхим

Уран баримал ба гар урлал

- 301 БУДДЫН УРАН БАРИМЛЫН ТАНХИМ
- 302 МЕТАЛЛ ГАР УРЛАЛЫН ТАНХИМ
- 303 СЕЛАДОН ШААЗАНГИЙН ТАНХИМ
- 304 БУНЧЁНГ ТАНХИМ
- 305 ЦАГААН ШААЗАН ЭДЛЭЛИЙН ТАНХИМ

Азийн урлаг

- 306 Энэтхэг болон Зүүн өмнөд Ази
- 307 Төв Ази
- 308 Хятад
- 309 Синанд живсэн хөлөг онгоцны эд зүйлс
- 310 Синанд живсэн хөлөг онгоцны эд зүйлс
- 311 Япон

ТҮҮХЭН ЗАМНАЛ

ТҮҮХЭН ЗАМНАЛ

1. Чи үүнийг яагаад “гар сүх” гэж нэрлэсэн гэж бодож байна вэ?

- ① Үүнийг гараар хийсэн байна.
- ② Энэ гар сүх хүний зангидсан гар буюу нударга шиг том байна.
- ③ Энэ хүний нударгатай адилхан байна.
- ④ Энэ сүхэн дээр гарны дүрс байна.




2. Энэ зүйлийг голдуу юунд хэрэглэдэг байсан бэ?

- ① Хоол хадгалах сав
- ② Усны хувин
- ③ Сангийн бойпор
- ④ Толгой хамгаалах дуулга



ХҮРЭЛ ЗАН ҮЙЛИЙН ЭДЛЭЛ

3. Хүмүүс үүгээр юу хийдэг байсан бэ?



- ① Мал өсгөх
- ② Загасчлах
- ③ Тариалан эрхлэхэд
- ④ Бүжиглэхэд



НУГАСАН ДҮРСТЭЙ ШАВАР ЭДЛЭЛ

4. Эдгээр шавар эдлэлийг юунд ашигладаг байсан бэ?



- ① Лаа тогтооход
- ② Өрөө чимэглэхэд
- ③ Баяр ёслолын үед юм уухад
- ④ Эмэгтэйчүүдийн загварын эд зүйл

5. Энэ туургыг хаанаас малтаж гаргасан бэ?

① Шилтгээн

② Дайны талбар

③ Сургууль

④ Бунхан



6. Энэхүү сангийн бойпорын таган дээрх хөгжмийн зэмсэг тоглож байгаа хэчнээн хүнийг та олж чадах вэ?

① 3 хүн

② 5 хүн


③ 7 хүн

④ 9 хүн



ЯЛТСАН ХУЯГ, ДУУЛГА

7. Хуягны ялтас бүрийг сайтар ажиглаад дөрвөлжин дотор уг ялтаснуудын хэлбэрийг зурна уу.



ШИЛЛА АЛТАН БҮС

8. Доорх зүйлүүдийн аль нь Шилла алтан бүсэд хамаарахгүй вэ?



① Дэгээ

② Ном

③ Хаш чулуун зүүлт

④ Хуй



БИЧИГТЭЙ ШОО

9. Доорх зүйлүүдийн аль нь шоон дээр бичигдсэн шийтгэлүүдийн нэг биш вэ?

- ① Гижигдэж байхад хөдлөхгүй зогсч байх
- ② Санаанаасаа шүлэг зохиох
- ③ Ямар ч дуу чимээ гаргалгүйгээр бүжиглэх
- ④ Зогсож байгаа газраа 10 удаа тойрч эргэлдэх



ЛУУНЫ ТОЛГОЙ ЧУЛУУН ХӨШӨӨ

10. Үүнийг юунд ашигладаг байсан бэ?

- ① Шилтгээн чимэглэхэд
- ② Чулуун хөшөөний толгой болгож
- ③ Пагодаг чимэглэхэд
- ④ Хотын таних тэмдэг болгож



АНАР ДҮРС БҮХИЙ УСНЫ ГООЖУУР

11. Сармагчин ямар жимс тэвэрсэн байна вэ?

- ① Чавга
- ② Алим
- ③ Анар
- ④ Тоор



12. Тайлбар бүрийг чулуун авсны дөрвөн талын дүрснүүдтэй тааруул.



①

① Зүүн зүгийг
хамгаалдаг хөх луу



②

② Баруун зүгийг
хамгаалдаг цагаан бар



③

③ Өмнө зүгийг
хамгаалдаг галт шувуу



④

④ Хойд зүгийг
хамгаалдаг яст мэлхий




13. Энэ зүйл яагаад ардаа зууван хэлбэрийн хонхорхойтой байгаа вэ?

- ① Үүнийг хийсэн хүмүүс ашиглагдах зэсний хэмжээг багасгахын тулд ийм хонхорхой гаргасан.
- ② Ийм хэлбэр гаргахад бэрхшээлтэй байсан учир
- ③ Тухайн үед ийм хэлбэр гаргах арга түгээмэл байсан учраас
- ④ Малтлагын явцад гэмтсэн




14. Газрын зурагнаас Жусоныг олоод дугуйл.



15. Энэ зураг юу өгүүлж байна вэ?



- ① Одны орд ② Математик
③ Күнзийн сургаал ④ Ургын бичиг



16. Эрэгтэй хүмүүс хэдэн наснаасаа эхлэн энэхүү пайзыг биедээ авч явдаг вэ?





- ① 14 нас
② 16 нас
③ 18 нас
④ 20 нас



ДЭДОНГНЁЖИДО

17. Дэдонгнёжидогын тайлбарыг уншаад нүднүүдийг бөглөнө үү.

- ① Ким Жинг-хо Жусоныг хойд хэсгээс нь эхлүүлээд урд хэсэг хүртэлх 120 аймгаар үргэлжилсэн ____ хэсэгт хуваасан.
- ② Хэсэг бүрийг нэгдэх үед ____ хүчин болж бүрдэхээр зохион байгуулсан.



СОЛОНГОС ГҮРНИЙ ХААНЫ ТАМГА

18. Бариул дээр ямар амьтныг дүрсэлсэн байна вэ?


- ① Матар
- ② Луу
- ③ Нохой
- ④ Арслан



КИМ ЖЁНГ-ХУ ЧУСАГИЙН БИЧСЭН МУКСОГЁСАГИЙН МАГТАН ДУУЛАЛ

19. Уран бичлэгийн өрөөнд байгаа дээрх хүний бичсэн гурван өөр бичлэгийг та олж чадах уу?

1. _____ 2. _____ 3. _____



20. Зургийн цомгоос ямар ч хамаагүй нэг зураг сонгоод доорх хоёр асуултанд хариулна уу.



① Зурганд хэдэн хүн байна вэ?


② Энэ зургийг юу гэж нэрлэх вэ?

Жишээлбэл) 7 тоглогч нэг бүжигчин



21. Доорх зүйлүүдийн аль нь Сеон-бигийн (Жусоны эрдэмтэн) өрөөнд зохицолдохгүй вэ?

- ① Уншлагын ширээ ② Ном
③ Багс ④ Толь



22. Энэхүү хоёр үндэсний баялгийг хараад доорх асуултанд хариулна уу.

- ① Аль хөшөө нь нар, сараар чимэглэсэн титэмтэй байна вэ?
Үндэсний баялаг

- ② Аль хөшөө нь цээжиндээ хувцасгүй байна вэ?
Үндэсний баялаг



Үндэсний баялаг No.78



Үндэсний баялаг No. 83

АРИУН ШҮТЭЭНИЙ САВ

23. Энэхүү нандин хайрцагийг “Ариун шүтээний сав” гэж нэрлэдэг. Үүн дотор юу хийж хадгалдаг байсан бэ?

- ① Лам нарын чандар
- ② Буддын уран баримал
- ③ Буддын зураг
- ④ Хувцас



ЛЯНХУА ЦЭЦГИЙН СИЙЛБЭРТЭЙ СЕЛАДОН

24. Гоёмсог шаазанг сайтар хараад тохирох өнгийг дугуйлж тэмдэглэнэ үү.



- | | |
|-----------|-----------|
| Хөх | Хөх ягаан |
| Улаан | Хар |
| Оюу | Шар |
| Ногоон | Саарал |
| Цагаан | Саарал |
| Улбар шар | |

ЯСТ МЭЛХИЙН ДҮРСТЭЙ САВ

25. Үүнийг юунд ашигладагбайсан бэ?

- ① Ус, шингэн зүйл авч явдаг сав.
- ② Үнэртэй ус хадгалдаг сав
- ③ Бэх найруулахад хэрэглэгддэг усны сав
- ④ Цэцэгний ваар



ЧАВГА, ХУЛС МОДТОЙ ЦАГААН ШААЗАН

26. Энэ шаазанг ямар хоёр ургамлаар чимэглэсэн байна вэ?

- ① Чавганы мод
- ② Цахирмаа цэцэг
- ③ Удвал цэцэг
- ④ Хулс




АРВАН-ШАСТИРТ ПАГОДА



27. Пагода дотор нэгэн бичээс байдаг.
Юу гэсэн бичээс байдаг вэ?

- ① Буддизм
- ② Таозм
- ③ Жудизм
- ④ Христ




БОСИНГАК ХОНХ

28. Босингок хонхыг гол нь юунд ашигладаг байсан бэ?



- ① Дайсны дайралтаас сэргийлэхэд
- ② Хааны айлчлалыг мэдэгдэхэд
- ③ Цайзын хаалга нээгдэж, хаагдах цагийг зарлахад
- ④ Буддын сүмд мөргөлийн цаг эхлэсэнийг зарлахад



ГУРВАН-ШАСТИРТ ПАГОДА

29. Пагодаг хараад зөв нэрийг зурагтай нь сонгож тохируул.

Өнгөлгөөний чулуу ①

Багана ②

Хөшөөний суурь ③

Ⓐ

Ⓑ

Ⓒ



САНЧЕОНГ МАЧОН-РИ БАЛГАСЫН ДОЛЬМЕН

30. Энэ дольмений доор юу байгаа вэ?

① Худаг

② Хонгил

③ Агуулах

④ Бунхан



ХАРИУЛТ БА ТАЙЛБАР!

1. ГАР СҮХ, ПАЛИОЛИТЫН ҮЕ

Энэхүү гар сүхийг Гёнгидох Жонгок-ри, Ёнчеоны балар эртний үеийн газраас малтлага хийж олсон. Шовх үзүүртэй, иртэй гар сүх нь хүн төрөлхтөн хамгийн анх багаж зэвсэг үйлдвэрлэж эхлэх үед буюу 1 сая жил өнгөртөл ил харагдаагүй юм. Энэхүү гар сүх нь хүмүүс дөнгөж чөлөөтэй сэтгэж, тэсч үлдэх чадвартай болж эхлэх үед бүтээгдсэн учир хүн төрөлхтөний түүхэн хувьслын үнэт эд өлгийн зүйл юм. **ХАРИУЛТ – 1**

2. ЗУРААСАН ХЭЭ БҮХИЙ САВ, ШИНЭ ЧУЛУУН ЗЭВСГИЙН ҮЕ

Шинэ чулуун зэвсгийн өв соёлыг тод харуулсан энэхүү сав МЭӨ 6000 жилийн өмнөх Солонгосын Пенинсулагаас анх олдсон билээ. Савыг тэр чигт нь зураас, цэгээр чимэглэсэн байгаа нь тухайн эрин үеийн гоо сайхны чиг хандлагыг илэрхийлж байгаа юм. Ийм хээг гаргахад тусгай зориулалтын багаж хэрэгсэл ашигласан байна. Энэхүү сав нь багаж хэрэгсэл хийх арга техникийн хөгжлийг харуулахын зэрэгцээ яс, чулуу зүсч хүссэн хэлбэрээ гаргах, бүхэлд нь билүүдэж өнгөлөх зэрэг үйлийг тодхон харуулж байна. Хоол хүнс хайх, хадгалахад багаж зэвсгийн хөгжлийн үе шат улам сайжарсан байна. **ХАРИУЛТ - 1**

3. ХҮРЭЛ ЗАН ҮЙЛИЙН ЭДЛЭЛ, ХҮРЭЛ ЗЭВСГИЙН ҮЕ/ГОЖОСЕОН

Энэхүү эдлэлийн баруун урд талд газар ухаж байгаа хүн, зээтүү барьсан хүнийг дүрслэн сийлсэн байна. Мөн зүүн талд вааранд юм хийж байгаа хүн, эсрэг талд нь мод түүний мөчир дээр сууж байгаа хоёр шувууг дүрсэлсэн байна. Иймээс энэ нь Хүрэл зэвсгийн үеийн тариалангийн ажлыг нарийвчлан үзүүлсэн эд зүйл билээ. Мөн тухайн цаг үеийн уран зургийн нэгээхэн үеийг харуулсан зүйл ч байж мэдэх юм. **ХАРИУЛТ-3**

4. НУГАСАН ДҮРСТЭЙ САВ, БУЁО/САМАН

Ёслолын арга хэмжээний үед өвөг дээдэстээ уух юм өргөн барихад уг савыг хэрэглэдэг байжээ. Түүхэнд тэмдэглэснээр энэ шувуу нь сүнсийг хойд насанд аваачдаг гэсэн байдаг ба тиймээс ч нас барсан хүний сүнсийг диваажинд аваачихад зуучилдаг гэж энэхүү шавар савыг билэг тэмдэг болгон үздэг байжээ. **ХАРИУЛТ-3**

5. АНГИЙН ҮЙЛ,ГУГУРЁ

Солонгосын ард түмний дунд хамгийн сайн танигдсан урлагын өв бол Гугурёгоос дамжин ирсэн бунхны зураг юм. Бунхны дотор талыг зураг чимэглэсэн байна. Гугурё улс газар нутгаа тэлэх явцад олон улс гүрний соёлтой ойр дотно болж байхад буюу 04-р зууны дараа түүний дийлэнх нь хийгдсэн байдаг. Туурган дээрх хээ нь бунхныг хэзээ хийгдсэн талаарх нууц зүйлийг хэлж өгдөг байжээ. **ХАРИУЛТ-4**

6. САНГИЙН БОЙПОР, БЭКЖЭ

Тавиур, их бие, тагаас бүрдсэн энэхүү сангийн бойпорыг хаант төрийн ёслолын арга хэмжээний үед ашиглаж байжээ. Энэхүү ер бусын шилдэг бүтээлийг хүчит луу, лянхуа цэцгийн цоморлиг, хөгжмийн зэмсэг тоглож байгаа тэнгэрлэг байдлыг дүрслэн харуулж гайхалтай сайхан хэлбэр гарган сийлбэрлэсэн байна. Мөн Галт шувууг таган дээр байрлуулж өгсөн. **ХАРИУЛТ-2**

7. ЯЛТСАН ХУЯГ, ДУУЛГА, ГАЯА

Энэхүү хуягыг Гёсанбүкын Гүрүёнг дахь 32-р бунханаас ухаж гаргасан. Урт төмөр ялтсыг хооронд нь хадаасаар холбож тогтоосон байгаа.Ийм төрлийн хуяг өөр бусад орон нутгаас олдож байснаас үзвэл Гурван хаант улсын үед нэлээдгүй хэрэглэгдэж байсан бололтой. Дайчны толгойг илүү сайн хамгаалахын тулд дуулганы дунд хэсгийг өнцөглөж өгсөн ба хүзүү хамгаалах гурван төмөр ялтсыг дуулганы доод хэсэгт суулгаж өгсөн байна. Гаяад хуяг нь практикт хэрэглэгдээд зогсохгүй хүч чадлын бэлэг тэмдэг болдог байсан. **ХАРИУЛТ- ЗУРГААСАА ХАМААРНА.**



8. АЛТАН БҮС, ШИЛЛА

Энэхүү бүс нь арьсан дотортой, төмөр чимэглэлтэй ба мөн төрөл бүрийн хээг дүрсэлсэн унжлагатай. Дийлэнх бүс нь 10-аад унжлагатай байдаг ба энэ нь жижиг хаш чулуу, нарийн алтан ялтас, жижиг хутга,дэгээ, зүү,билүүнээс бүрддэг. Эдгээр чимэглэлүүдийг голдуу Хойд Азийн нүүдэлчид бүсэндээ зүүж Шиллагийн урлаг, Хойд Азийн амьдралын өвөрмөц хэв маягийг илэрхийлдэг байсан. **ХАРИУЛТ-2**

9. БИЧИГТЭЙ ШОО, НЭГДСЭН ШИЛЛА УЛС

Нэгдсэн Шилла улсын үед язгууртнууд уг шоог тоглоом наадамд ашигладаг байжээ.Энэ нь 14 талтай бөгөөд тал бүрт нь шийтгэл бичсэн байдаг. Уг шоог Анапжи, Хааны амралтын цөөрмөөс ухаж гаргажээ. Энэ газар нь Шиллагийн гол ордон болох Волсеогын зүүн талд байрлах хунтайжийн ордонтой холбоотой. **ХАРИУЛТ-4**

10. ЛУУНЫ ТОЛГОЙ, БАЛЕ

Балегийн уран барилгыг хааны ордон, түшмэлийн газар, орон гэр, сүм хийдийн үлдцээс судлаж болно. Эдгээр барилга, байгууламж нь хотын ханын гадна ба дотор талд байрладаг. “Лууны Толгой”-н баримлыг нэг талаас шилтгээний гадна үзэмжинд зориулж нөгөө талаас муу ёрын зүйлээс шилтгээнийг хамгаалахын тулд хийсэн байна. **ХАРИУЛТ-1**

11. АНАР ДҮРСТЭЙ УСНЫ ГООЖУУР, ГҮРЁ

Энэхүү усны гоожуурыг Гурёгын нийслэл хот болох Гегёнг дахь дээд зэрэглэлийнхэн хэрэглэдэг байсан бололтой. Амандаа анар жимс зуусан сармагчингийн амнаас ус гоожиж буй бүтээл. **ХАРИУЛТ-3**

12. ЧУЛУУН АВС, ГҮРЁ


Энэ бол Гурё улсын үед амьдарч байсан Хе Жа эрдэмтний чулуун авс. Ийм жижиг хэлбэрийн авсыг тухайн үед нийтлэг хэрэглэж байжээ. Авсны дөрвөн талд шүтээн болох яст мэлхий, цагаан бар, галт шувуу, хөх луу мөн 12 амьтны ордыг гадна талд сийлж өгсөн нь сайн сайхны билэг тэмдэг болж өгч байгаа юм. **ХАРИУЛТ-А-2, В-1, С-4, D-3**

13. ГҮРЁ ҮЕИЙН МЕТАЛЛ

Гурёгийн үеийн анхны металл төрөл нь Хятадын “Бок”-с үлгэрлэсэн. Түүнийг Гурёгийн нийслэл болох Гесёнг хотын бунхны малтлагаас олсон. Хэлбэр нь адилгүйн дээр талуудын урт нь мөн тэгш бус. Олдворын ар нь зуйван хэлбэртэй, хонхорхой байгаа нь хэрэглэгдэх зэсний хэмжээг багасгах бодлоготой холбоотой. Хэдийгээр энэхүү олдвор нь Жусоны үеийн сүүлд хийгдсэн бүтээлийг арай гүйцэхгүй боловч Солонгосын үсэг өрөлтийн арга техникийн түүх болохын зэрэгцээ Гурё улсын металаар эд зүйл хийх мэдлэгийг харуулахад ач холбогдолтой болсон юм. Зөвхөн өөр нэг төрлийн металлыг Гурёгийн үеэс авч үлдсэн ба энэ нь одоо Хойд Солонгосын Гасонг музейд хадгалагдаж байна. **ХАРИУЛТ-1**

14. ТҮҮХЭН ХОТУУДЫН НЭГДСЭН ГАЗРЫН ЗУРАГ, ЖУСОН

1402 онд хийгдсэн “Түүхэн хотуудын нэгдсэн газрын зураг”-с үзвэл Солонгос улсыг хөрш орнуудтай нь харьцуулахад харьцангуй том газар нутагтай байсан мэт харагддаг. Ийм чиг хандлага улс орноороо бахархах Солонгос хүмүүийн ярианаас үүдэлтэй. Энэхүү газрын зурагны тэмдэглүүштэй нь тухайн үеийн Солонгосчуудын мэддэг тивүүд болох Араб, Европ, Африк тивийг хамруулсан байсан. Хятад, Солонгос хоёр улсыг уг газрын зураг дээр тод томруун нарийвчлан харуулжээ. **ХАРИУЛТ-ЗУРГААСАА ХАМААРНА.**



15. КҮНЗИЙН СУРГААЛЫН ГОЛ ҮЗЭЛ САНААНЫ ТУХАЙ ЗУРАГЛАЛ

16-р зуунд хөдөө тосгоны Күнзийн сургаал номлогчийн шинэ үеийнхэн сургууль нээж улс төрийн бүлэглэл бий болгосон байна. Тэд хот суурин газрынхны хүнд суртлын эсрэг байр суурьтай байж улмаар хааныг шинэ Күнзийн сургаалыг сурч улс орныг шинээр олж авсан мэдлэгийнхээ хүрээнд захирах хэрэгтэй хэмээн үзсэн юм. Тэдний энэ алхам бүлэглэлийн бодлогын онолын үндэс болсон юм. **ХАРИУЛТ-3**

16. ПАЙЗ, ЖУСОН

Жусоны үед 16 нас хүрсэн эрэгтэй хүн бүр нэр ус, төрсөн он, сар өдрийг нь бичсэн пайз зүүж явах ёстой байжээ. Энэхүү пайзыг захиргаанаас олгодог байсан ба тухайн хүний зэрэг зиндаа, хийж байгаа ажил зэргээс нь шалтгаалан янз бүрийн материалаар хийдэг байжээ. Тухайлбал 1677 онд 2-с дээш зэрэгтэй төрийн албаны хүн зааны ясан пайз, 3-с доош зэрэгтэй хүн үхрийн арьсан пайз, энгийн ард иргэд модон пайз биедээ авч явдаг байжээ. Мөн тухайн хүн уг пайзыг хүлээн авах үедээ тооллогонд хамрагдан бүртгүүлж цэргийн алба хаах ёстой байдаг байна. Дийлэнх энгийн иргэд энэ үүргийг хүлээх дургүй байсан тул пайзаа биедээ байнга авч явдаггүй байснаас захиргаанаас пайзаа мартахын эсрэг хууль, тогтоомж гаргасан гэдэг. **ХАРИУЛТ-2**

17. ДЭДОНГНЁЖИДО, ЖУСОН

Ким Жинг-Хо 1861 онд далдуу модоор энэхүү Дэдонгнёжидо модон сийлбэрийг урласан боловч дараа нь хэд хэдэн удаа засч янзалжээ. Ким Жинг-Хогийн хийсэн (1804-1866) Их Зүүн гүрний газрын зураг (Дэдонгнёжидо) нь Жусоны үеийн сүүлийн хэдэн сайн газрын зургийн нэг нь болж чадсан юм. Уг газрын зураг дээр нийт газар нутаг нь хойд зүгээс урд зүгийг хамарсан 120 аймгаар үргэлжилсэн 22 хэсэгт хуваагдсан байлаа. Хэсэг бүрийг нэгтгэх үед нэг том хүчин болж бүрдэхээр зохион байгуулсан. **ХАРИУЛТ-22,1**

18. СОЛОНГОС ГҮРНИЙ ХААНЫ ТАМГА

Хаан Гожонг хаан ширээнд залрах үедээ улс орноо “Солонгос гүрэн” хэмээн зарлан тунхаглажээ. Тэрээр шинэ гүрнийхээ нэр сүрийг өндөрт өргөхийн тулд танхимаа дахин зохион байгуулж албан тушаалын нэрийг ч өөрчилсөн байна. Тэр ч байтугай шинэ гүрний сүр хүчинд зохицуулж Хаант төрийн тамгыг өөрчилсөн юм. **ХАРИУЛТ-2**

19. КИМ ЖЁНГ-ХУ ЧУСАГИЙН БИЧСЭН МУКСОГЁСАГИЙН МАГТАН ДУУЛАЛ -ЖУСОН

Ким Жёнг-Ху энэхүү уран бичлэгтээ Муксогёсаг магтан дуулсан байдаг. (Чимээгүй ба инээдэм) Энэ нь түүний хэд хэдэн алдартай бүтээлүүдийн нэг юм. Үүнийг орчуулбал “Дуугүй байхад дуугүй бай, инээдтэй байхад инээ, тэгвэл алтан дундажид ойртоно.” Энэхүү уран бичлэг нь этгээд, марзан байдлыг харуулсан. **ХАРИУЛТ- ЯЛГАРНА.**

20. ДАНВОНЫ ЗУРГИЙН ЦОМОГ (КИМ ХОНГ-ДО) ЖУСОН

Зургийн мастер Ким Хонг-До (1745-1806) янз бүрийн аж амьдралтай энгийн ард иргэдийн ахуйг судлаж үзээд тэдний амьдралын дүр зургийг арай өөр шог хошин хандлагаар дүрслэн зуржээ. Энэ зургийг бөмбөр, элсэн цаг хэлбэртэй бөмбөр, хулсан цоор, том хулсан лимбэ, хоёр чавхдаст хуур зэрэг Солонгосын үндэсний хөгжмийн зэмсгийн аянд бүжиглэж байгаа хөвгүүний хөгжилтэй хөдөлгөөнийг тойрог маягаар зурж харуулсан байна. **ХАРИУЛТ- ЯЛГАРНА.**

21. САРАНБАН, ЖУСОН

Жусоны үед шинэ Күнзийн урсгалаас улбаалаад эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн үүрэг, байр байдал өөр болж хувирсан байв. Нэг гэр бүлд хүртэл эрэгтэй эмэгтэй хүмүүс хоорондоо Саранбан буюу гэрийн эзний байр, Анбан буюу эзэгтэйн байраар өөр хоорондоо тусгаарлагддаг байсан

байна. Саранбан нь Анбаныг бодвол илүү өргөө гэр шиг байсан ба энэ нь эрдэмтдэд ихээхэн ач холбогдолтой байжээ. **ХАРИУЛТ-4**

22. БОДЛОГОШИРСОН БОДСАДВА, ГУРВАН ХААНТ УЛСЫН ҮЕ

78-р үндэсний баялаг нар, сараар чимэглэсэн өндөр титэмтэй. Ийм төрлийн титэм Сасаниан Персигээс анх үүссэн. Учир битүүлэг инээмсэглэл, энгийн төрх, эвлэг бие, айзамт хувцсаараа 83-р Үндэсний баялаг Бодсадвагын уран баримлаас ялгарч байгаа юм. Энэ хоёр баримлын хэлбэрийн хувьд авч үзвэл хоёулаа нэг хөлөө нөгөө хөл дээрээ ачиж хуруугаа хацрандаа хүргэн бодолд автсан шинжтэй байна. Энэ нь хүмүүний амьдралыг бясалган суух Буддагийн дүрийг дуурайлгасан дүр төрх юм. 83-р Үндэсний баялаг Бодсадваг “Гурван уулын титэм” эсвэл “Лянхуан титэм” хэмээх тэгш хавтгай титэм өмссөнөөр урласан байна. Түүний нүцгэн биед энгийн хүзүүний зүүлт урласан байгаа нь Японы Киото дахь Коружи хийдийн модон Бодсадваг санагдуулам билээ. Энэ модон Бодсадваг Шилла лам олсон хэмээгддэг. Үүнтэй холбоотойгоор энэхүү хөшөө баримал нь Шиллагийн үед бүтээгдсэн гэж зарим хүмүүс үздэг. Гэхдээ уран баримлын маш сайн тооцоолсон хэлбэр дүрс, тансаг, нарийн гар урлалын бүтээл гэдгээр нь Бэкжэгийн үеийн уран баримал хэмээн тодорхойлох байх. **ХАРИУЛТ-78,83**

23. АРИУН ШҮТЭЭНИЙ САВ, НЭГДСЭН ШИЛЛА УЛС

Гаменса Хийдийг 682 онд Синмун хаан өөрийн нас нөхцсөн аав болох Гурван Хаант улсыг нэгтгэсэн Мунму хааны дурдатгалд зориулан үүсгэн байгуулжээ. Өнөө үед зөвхөн зүүн, баруун пагода болон хийдийн газар үлджээ. Хүрэл ариун шүтээний савыг зүүн болон баруун пагодагийн 3-р давхраас олсон бөгөөд тус бүр нь “сарира” буюу ихэвчлэн Буддын лам нарын чандараас олддог нунтаг агуулсан болор савтай байжээ. Зүүн пагодагаас олсон ариун шүтээний сав нь Нэгдсэн Шилла улсын үеийн металл гар урлалын нарийн тансаг байдлыг харуулсан урлагийн бүтээл юм. **ХАРИУЛТ-1**

24. ЛЯНХУА ЦЭЦГИЙН СИЙЛБЭРТЭЙ СЕЛАДОН

Энэхүү селадон ваар нь гайхалтай гоёмсог ногоон цэнхэр гялалзсан өнгөтэй, гоёл чимэглэлийн сийлбэртэй бөгөөд Солонгос оронд нийтлэг байдаг. Түүний гадна талын хөнгөн зураас бүхий хосгүй сийлбэр нь Гурё селадоны шинжийг төгс дэлгэн харуулж байна. Мөн лянхуа цэцэг, ороонго мөчир нь ногоон цэнхэр өнгөтэй нийлэн уг савыг үзэсгэлэнтэй харагдуулж байна. **ХАРИУЛТ- ЯЛГАРНА.**

25. ЯСТ МЭЛХИЙН ДҮРСТЭЙ САВ, ЖУСОН

Энэ савыг хавтгай, дугуй хэлбэртэй, амсартай болохоор нь “Яст мэлхийн дүрстэй” гэж нэрлэсэн. Жусон улсын үед түүнийг ус, шингэн зүйл авч явдаг дашмаг болгон хэрэглэдэг байсан. Өдөр тутмын амьдралд шавар вааран эдлэл хэрэглэгддэг болсноос хойш Бунчёнг цагаан шаазан эдлэл ховордсон. Савны дээд талын зузаан цагаан хэсэгт цэнэ цэцгийг уран гоё дүрслэн үзүүлсэн байна. Загварын хувьд маш бат бөх болсны дээр дээд талын цагаан хэсэг болон үлдсэн бүх хэсгийг төгс сайхан хийжээ. Цэнэ цэцгийг урлахдаа эхлээд гадаргууг хусч цэвэрлэн дараа нь улам бүр өвөрмөц харагдуулахын тулд боронзон лакаар будаж өгсөн байна. **ХАРИУЛТ-1**

26. ЧАВГА, ХУЛС МОДТОЙ ЦАГААН ШААЗАН, ЖУСОН

Цэвэр ариун байдал, тэсвэр тэвчээрийн билэгдэл болгож хийсэн энэхүү цагаан шаазан эдлэлийг Күнзийн сургаалыг дэмжигч язгууртан, ихэс дээдэс ихэд хайрлан дээдэлдэг байжээ. Шаазан ваарны гадна талыг чавганы мод, хулс зэргийг зурах хэрэгсэл болгож байв. Өнгө, дизайны нарийн шийдлээс үзвэл үүнийг хааны ордны зураач зурсан шинжтэй байна. **ХАРИУЛТ-1, 4**

27. АРВАН ШАСТИРТ ЧУЛУУН ПАГОДА, ГҮРЁ


Энэхүү 10-шастирт чулуун пагодаг Гурё улсын үед буюу 1348 онд гантигаар бүтээжээ. Суурь нь Хятадын сонгодог зохиол Юужигийн түүхэнд өгүүлсэн арслан, лянхуа, даяанч болон бусад төрлийн сийлбэртэй. Нийлээд Буддын зан үйлийн 16 сэдвийг үзүүлдэг. Энэ загвар нь модон уран барилгыг санагдуулам ба тухайн цагийн Буддын номлолыг зохих ёсоор дүрслэн үзүүлдэг. **ХАРИУЛТ-1**

28. БОСИНГАК ХОНХ, ЖУСОН

Энэхүү хүрэл хонхыг Сэжо хаан төр барьж байсан 14-р онд Сөүлийн Вангакса хийдэд /одоогийн Тапгол цэцэрлэгт хүрээлэн/ анх цутгаж хийсэн байна. (1468). 16-р зуунд уг хийд хаагдаж хонхыг хэд хэдэн газарт байрлуулж байсны эцэст Вангагүн хаан төр барьж байсан 11-р онд Босингак-д бүрмөсөн суурилуулсан юм. (1619) Хонхыг өдөр бүр буюу өглөөний 4 цагт 33 удаа, оройн 10 цагт 28 удаа дуугаргаж цайзын хаалга нээж, хаахыг мэдэгддэг байжээ. **ХАРИУЛТ-3**

29. ГУРВАН-ШАСТИРТ ЧУЛУУН ПАГОДА, ШИЛЛАГЫН НЭГДСЭН УЛС

Эдгээр пагода нь Галангса хийдийн хашааны зүүн болон баруун хэсэгт оршдог. Шилагийн Нэгдсэн улсын үед Буддын хийдийн гол танхимын урд давхар пагода барих нь заншил болсон байлаа. Гёндок Хаан төр барьж байсан 17-р онд зүүн пагоди дээрх бичээсийг дахин засварласан байна. (758) **ХАРИУЛТ – ЗУРГААС ХАМААРНА.**



30. САНЧЕОНГ МАЧОН-РИ БАЛГАСЫН ДОЛЬМЕН

Энэхүү балгасын дольмен дунд зөвхөн дугариг дольмен нь (1,3,5) оршуулгагай. Тэгэхээр оршуулгагүй гонзгой дольмен нь оршуулгын зан заншилтай холбоотой тахилын ширээтэй байжээ. 7-р Дольмен нь дугуй боловч оршуулгагүй. Голд байгаа өндөр, бүхэл чулуу нь чиглүүлэгч чулууны үүргийг гүйцэтгэдэг. Энгийн Долмен нь оршуулган дээр тавьсан том өнгөлгөөний чулуунаас бүрдэнэ. Гэхдээ энэ нь хойд зүгийн хүмүүсийн дунд түгээмэл “Хуваагдмал төрлийн дольмен”-г харуулж байна. Хуваагдмал төрлийн дольменыг дугуй эсвэл гонзгой хэлбэртэй болгохын тулд чулуунуудыг оршуулга тойруулан тавьдаг байна. Эдгээр Дольмен нь МЭӨ 5-4 зуунд хамрагдана. **ХАРИУЛТ-4**

Манай музейн танхимд

Бид!

Нам дуугаар ярьцгааж, зөөлөн явна уу

Үзмэрийг нүдээр харж, сэтгэлээрээ мэдэрцгээ.

Үзмэрийн талаар зөөлөн дуугаар ярина уу.

Үзэсгэлэн үзэхдээ гар утсаа унтраана уу.

Хүнсний зүйлийг зөвшөөрөгдсөн газарт хэрэглэнэ үү.

Хогоо зориулалтын саванд хаяна уу.

Үзмэрийн зургийг авахдаа тусгай хөл, гэрэлтүүлэгч
хэрэглэхийг хориглоно.



NATIONAL MUSEUM
OF KOREA